



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/173

Алтай хот

Хурдан морины уралдаан зохион
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн морин спорт, уяачдын холбооны саналыг харгалзан аймгийн хаврын бүсийн хурдан морины уралдааныг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр азарга, их нас, соёолон, сонгомол дээд насны ангиллаар Бигэр, Бугат сумдад, "Алтайн хавар-2023" бага 3 насны хурдан морины уралдааныг 06 дугаар сарын 02-ны өдөр Есөнбулаг сумд тус тус зохион байгуулахыг дэмжсүгэй.

2.Хурдан морины унаач хүүхдүүдэд стандартын шаардлага хангасан хувцас хэрэгсэл өмсгөх, эцэг эх,асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, олон нийтийн хэв журмыг сахиулж, хяналт тавин тайлагнаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Алтайбаатар), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), аймгийн Морин спорт, уяачдын холбоо (С.Магнайсүрэн)-нд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР